



УНШИЖ ОЙЛГОХ ЧАДВАРЫН СУДАЛГАА

Д.Ганболд
МУБИС-Багшийн сургууль, ахлах багш, доктор

Холбоо барих зохиогч: ganbold.d@msue.edu.mn

Хүлээн авсан: 2023.11.11

Хянагдсан: 2023.12.12

Зөвшөөрсөн: 2023.12.25

Хураангуй

Энэхүү бичил судалгаа нь 5 дугаар ангийн сурагчдын эхийн гол санааг тайлбарлах, мэдээллийг харьцуулан дүгнэх чадварыг тодорхой хүрээнд илрүүлэх зорилготой. Судалгааны үр дүнгээс харахад сурагчид эхийн гол санааг тайлбарлаж, мэдээллийг харьцуулан дүгнэж байгаа боловч, харьцуулах, жиших, нэгтгэн дүгнэх чадвар сул байгааг 29.4% нь эхээс аль нэг өгүүлбэрийг идэвхгүй хуулж бичдэг, 32.9% нь мэдээллийг боловсруулж чадаагүй байгаагаас харагдаж байна. Энэ нь бага ангийн сурагчдын уншиж ойлгох чадварыг хөгжүүлэхийн тулд унших стратегийг заах шаардлага байгааг харуулж байна. Схемийн онолын хувьд авч үзвэл уншиж ойлгоход суурь мэдлэг чухал үүрэгтэй тул сурагчдын унших агуулгын хүрээг өргөжүүлж, шинжлэх ухаан танин мэдэхүйн эхийг нэмэлтээр уншуулах хэрэгтэй.

Түлхүүр үг

Гол санаа, мэдээлэл, харьцуулан дүгнэх, унших стратеги, схемийн онол, идэвхгүй хуулж бичих, PISA, шинжлэх ухаан танин мэдэхүйн эх

Удиртгал

Судалгааны зорилго

5 дугаар ангийн сурагчдын эхийн гол санааг тайлбарлах, мэдээллийг харьцуулан дүгнэх чадварыг сорил (тест)-ын аргаар авч, цаашид хэрхэн сайжруулж болох талаарх саналыг дэвшүүлэх


Судалгааны зорилт

1. 5 дугаар ангийн сурагчдаас түүврийн аргаар уншиж ойлгох чадварын судалгаа авах
2. Судалгааны үр дүнг боловсруулж, үр дүнг задлан шинжилж тайлбарлах
3. Уншиж ойлгох чадварыг сайжруулах санал боловсруулах

Судалгааны асуудал

PISA¹ нь 15 настай суралцагч унших, математик, байгалийн ухааны мэдлэг, ур чадвараа бодит амьдралын сорилтуудыг даван туулахад хэрхэн ашиглаж байгааг тодорхойдог олон улсын түвшинд зохион байгуулагддаг үнэлгээний хөтөлбөр юм. Монгол Улсын хувьд 2022 онд анх удаа PISA-д хамрагдсан бөгөөд 7276 суралцагч оролцож, мэдлэг, ур чадварын түвшин Математик-425, Унших чадвар-378, Байгалийн ухаан-412 гэж үнэлэгдлээ. Унших чадварын үнэлгээний хувьд авч үзвэл OECD-ийн дундаж 67 хувьтай, Монгол улс 36 хувьтай байна (Зураг 1). Энэ нь судалгаанд хамрагдсан сурагчдын хувьд авч үзвэл 10 сурагч тутмын 6 нь уншиж ойлгох чадварын хувьд хөгжүүлэх шаардлага байгааг харуулж байна (PISA 2022, National Report).

Зураг 1. Мэдлэг, ур чадварын түвшин



Судалгааны арга, хамрах хүрээ

Унших чадварын хүрээнд сурагчдын эзэмшсэн мэдлэг, ур чадварыг илрүүлэх зорилгоор 5 ангийн 1000 сурагчийг хамруулан судалгааг зохион байгуулсан бөгөөд үр дүнг SPSS программ ашиглан, статистик боловсруулалт хийж гаргасан.

Судалгааны ажлын онолын үндэс

Хэл шинжээчид, танин мэдэхүйн сэтгэл зүйчид ойлгох үйл явцад нөлөөлдөг гол хүчин зүйлийн харилцан хамаарлыг схемийн онолд тулгуурлан хөгжүүлсээр байна (Pearson P., 2017). Схемийн онол нь уншигч эхийн утга санааг ойлгох болон түүний агуулгаас суралцахад өмнөх мэдлэгээ хэрхэн үр дүнтэй ашиглаж байгаагаар тайлбарлагддаг (Rumelhart, 1980). Ойлгох гэдэг нь уншигч эхийн агуулгыг өөрийн суурь мэдлэгтэй холбох чадвар юм (An, 2013). Р.Андерсоны тэмдэглэснээр “ойлголтын бүхий л үйлдэл нь ертөнцийн тухай мэдлэгийг агуулдаг” (Anderson R. S., 1990). Уншигч бүр унших үйл ажиллагааны алхам тутамд уншсан эхийн утга санаагаар уялдаа холбоо бүхий загвар бүтээдэг гэж схемийн онолд ойлголтын талаарх конструктивист үзлийг дэвшүүлсэн (Smagorinsky, 2001) байдаг. Схемийг эхийн бүтэц, агуулга, соёлын тухай мэдлэг, хэл шинжлэлийн чадвар гэж ангилсан

1 <https://www.oecd.org/pisa/>

байдаг (Urquhart A.H, 2013). Өөрөөр хэлбэл, сурагчдын суурь мэдлэг хангалтгүй байх нь тэдний уншиж ойлгох чадварт нөлөөлдөг.

Уншиж ойлгох чадварын судалгаа

Бага боловсролын Монгол хэлний сургалтын хөтөлбөрийн “Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах” (4.1б), “Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг харьцуулах замаар эхийн агуулгыг ойлгосноо харуулах” гэсэн чадварыг илрүүлэх зорилгоор сорилын аргаар судалгааг зохион байгууллаа. (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Уншиж ойлгох чадварын судалгаа

Хувилбар		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Сорил-1	Valid	.0	208	32.9	32.9
		.5	186	29.4	29.4
		1.0	160	25.3	25.3
		2.0	79	12.5	12.5
		Total	633	100.0	100.0
Сорил-2	Valid	.0	77	21.0	21.0
		.5	139	37.9	37.9
		1.0	139	37.9	37.9
		2.0	12	3.3	3.3
		Total	367	100.0	100.0

Сорил-1 нь гол санааг тайлбарлах чадварыг илрүүлэх зорилготой бөгөөд судалгаанд хамрагдсан сурагчдын хувьд авч үзвэл 12.5% нь хангалттай түвшинд хариулж бичжээ. Энэ нь сурагчид сургалтын хөтөлбөрийн гол чадваруудыг төдийлөн сайн эзэмшээгүй болохыг илэрхийлж байгаа боловч 25.3% нь гол санааг ойлгосноо илэрхийлэх чадварт суралцаж байгаа, 29.4% нь хөгжүүлэх шаардлагатай, 32.9% нь онцгой анхаарах хэрэгтэй байгааг харуулж байна. Сорил-1 нь мэдээллийг уншаад ижил, ба ялгаатай талыг харьцуулан бичих байв. Даалгаврыг гүйцэтгэхдээ тухайн эхэд өгүүлж байгаа адуу, тахь хоёрын ижил ба ялгаатай талыг сурагчдын 12.5% олж, гол санааг дүгнэн бичиж чадсан бол, 25.3% нь ижил ба ялгаатай талын зөвхөн нэгийг тодорхойлсон. Харин 29.4% нь аль нэг өгүүлбэрийг эхээс шууд хуулж бичсэн байдаг бол 32.9% нь энэ чадварт суралцаагүй, онцгой анхаарах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Хүснэгт 2. Ижил ба ялгаатай шинжийг харьцуулан дүгнэх

А түвшин	В түвшин	С түвшин	Д түвшин
Эхийн гол санааг тайлбарласан 12.5%	Зөвхөн нэг шинжээр тайлбарласан 25.3%	Аль нэг өгүүлбэрийг эхээс шууд хуулж бичсэн 29.4%	Энэ чадварт суралцаагүй 32.9%
<i>Адуу тахь хоёр нь адил төрлийн хэргийг адуу, тахь хоёр төрлийн хэргийг харин тахь мөхөөллийн гэдэг үгэд байдаг</i>	<i>Адуу тахь хоёрын ялгааг эхээс харуулсан. Адуу тахь хоёр хоёртон амьтан гэдэг гэдэг байсан.</i>	<i>Адуу, хийнчартай амьтан гэж дотгоридаг. Харин тахь бол Монголын гэдэг гэдэг тал нутагт амьдардаг. Харин адуу тал.</i>	<i>Бал... амьтан... нууц... мийн... харин... зэрэгт Монголын гэдэг гэдэг гэдэг, Шийн... тахь...</i>

Хамгийн анхаарал татсан хэсэг бол “С” бүлэгт багтсан сурагчид бөгөөд эхээс 1-2 өгүүлбэрийг шууд хуулж бичсэн. Судалгаанд хамрагдсан сурагчдын хувьд юмсыг гадаад, дотоод шинжээр тоочиж бичих чадвар нь ассимиляци болсон, харин мэдээллийг нэгтгэн дүгнэх, тайлбарлах чадвар аккомодацид орсон байна. Л.В.Занков бага ангийн сургалтын агуулга хөнгөн, давталт ихтэй, хурд удаан, нэг үйл ажиллагааг олон удаа давтан хийлгэх нь сурагчдын эрчимтэй хөгжүүлэхэд саад болдог гэж үзжээ. Ж.Пиажегийн хэлсэнчлэн ассимиляци, аккомодацийн үрээр хүний оюун ухаан орчиндоо дасан зохицож хөгжиж байдаг тул сурагчдаар нэгэнт хийж чаддаг болсон зүйлийг нь дахин дахин хийлгэх биш, дараагийн хөгжүүлэх сургалт руу чиглэсэн үйл ажиллагааг хийлгэх нь багш нарын гол ажил юм. Бага ангийн сурагчид ихэнх цагаа хуулж бичих идэвхгүй даалгаварт зориулж байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан сурагчдын хувьд авч үзвэл 37.8% нь эхийн гол санааг тайлбарлаж чаддаг, энэ чадварт суралцаж байна. Харин 29.4% нь хөгжүүлэх, 32.9% нь онцгой анхаарах шаардлагатай байгааг харуулжээ.
2. Харьцуулах, жиших, нэгтгэн дүгнэх чадвар сул буюу 29.4% нь эхээс аль нэг өгүүлбэрийг шууд хуулж бичиж байна.
3. PISA судалгааны хувьд уншиж ойлгох чадвар 36 хувьтай байна. Энэхүү бичил судалгааны хувьд уншиж ойлгох чадвар 37.8% байна.

Санал

Энэхүү судалгааг цаашид өргөн хүрээг хамруулж үргэлжлүүлэхээр төлөвлөж байна. Бага ангийн сурагчдын уншиж ойлгох чадварыг хөгжүүлэхийн тулд унших техник эзэмшсэн буюу шууд унших арга барилтай болсны дараа унших ойлгох чадварыг хөгжүүлдэг стратегийг заах нь тулгамдсан асуудал болсон байна. Иймд багш бүр энэ арга зүйд суралцах шаардлагатай. *Схемийн онолын хувьд авч үзвэл* уншиж ойлгоход суурь мэдлэг чухал үүрэгтэй тул сурагчдын унших агуулгын хүрээг өргөжүүлж, шинжлэх ухаан танин мэдэхүйн эхийг нэмэлтээр уншуулах хэрэгтэй.

Ном зүй

- An, S. (2013). Schema Theory in Reading. ACADEMY PUBLISHER Manufactured in Finland, 132.
- Anderson, R. C. (1990). The psychology of learning and motivation: Inferences and text comprehension. Inferences about word meanings, 1-16.
- Pearson, P. (2017). The Roors of Reading Comprehension Instruction. New York: The Guilford Press.
- Rumelhart, D. (1980). Schemata: the building blocks of cognition. Journal of Behavioral and Brain Science, 35-58.
- Smagorinsky, P. (2001). If meaning is constructed, what is it made from?: Toward a cultural theory of reading. Smagorinsk, 133-169.
- Urquhart A.H, C. J. (2013). Reading in a Second Language: Process, Product, and Practice. New York: Taylor & Francis Group.

A STUDY OF READING COMPREHENSION

Ganbold.D

Ph.D., Lecturer, Teachers School, MNUE

Corresponding author: ganbold.d@msue.edu.mn 

Abstract

This micro-research aims to reveal the ability of 5th grade students to explain the main ideas of their mother and to compare and evaluate information in a certain context. According to the results of the research, the students explain the main ideas of the mother and compare and evaluate the information, but their weak ability to compare, compare and summarize is shown by the fact that 29.4% passively copy and write a sentence from the mother, and 32.9% were unable to process the information. This suggests that there is a need to teach reading strategies to develop reading comprehension skills in primary school students. In terms of schema theory, basic knowledge is important for reading comprehension, so students should expand the range of reading content and make them read additional scientific and cognitive sources.

Keywords

Main ideas, information, comparison, reading strategies, schema theory, passive copying, PISA, science, cognitive resources
